

Зам, тээврийн хөгжлийн сайдын
2017 оны ... дугаар сарын ... ны
өдрийн ... р тоот тушаалын
нэгдүгээр хавсралт

**АВТО ЗАМЫН САЛБАРЫН МЭРГЭЖИЛТНИЙ
МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ, МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ
ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монгол Улсын авто замын салбарын /цаашид салбар гэх / мэргэжилтний дипломын дараахь тасралтгүй мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах, мэргэшлийн зэрэг олгох, зэргийг сунгах уг үйл ажиллагаанд хяналт тавихтай холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Мэргэжилтэн гэдэгт авто зам, гүүрийн барилга, засвар арчлалт, материалын үйлдвэрлэл, зам, гүүрийн зураг төслийн инженер, авто замын барилгын машин тоног төхөөрөмжийн механикч, инженер, төсөвчин хамаарна.
- 1.3. Инженер нь дадлагажсан, тэргүүлэх, зөвлөх, төсөвчин нь мэргэшсэн ба тэргүүлэх гэсэн мэргэшлийн зэргийн шатлалтай байна.
- 1.4. Мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх сургалт, мэргэшлийн зэрэг олгох сунгах, цуцлах ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих, цаашид энэхүү тогтолцоог тасралтгүй сайжруулж боловсронгуй болгоход салбарын төрийн захиргааны төв байгууллагын Авто замын асуудал эрхэлсэн газрын дэргэд "Салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус Зөвлөл" /цаашид Зөвлөл гэх/ -ийн үйл ажиллагаа чиглэгдэнэ.
- 1.5. Салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах сургалтыг Авто замын асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагатай гэрээ байгуулсан эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ.
- 1.6. Мэргэшлийн зэрэг олгохтой холбогдсон эх материал, мэдээлэл бусад холбогдох баримт бичгийг сургалт зохион байгуулах эрх бүхий байгууллага архивын нэгж болгон хадгална.
- 1.7. Авто замын салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Салбарын асуудал эрхэлсэн Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батална.

**Хоёр. Авто замын салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх,
мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус зөвлөл**

- 2.1. Зөвлөл нь салбарын төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх, Авто замын асуудал эрхэлсэн газрын даргаар ахлуулсан орон тооны бус зөвлөл юм.
- 2.2. Зөвлөл нь салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох ажлыг холбогдох эрх зүйн актын дагуу удирдан зохион байгуулах, хэлэлцэх, шийдвэрлэх ажлыг гүйцэтгэнэ.
- 2.3. Зөвлөлийн гаргасан шийдвэрийг яамны төрийн нарийн бичгийн даргын тушаалаар баталгаажуулна.
- 2.4. Зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах үүргийг зөвлөлийн нарийн бичгийн дарга хариуцна.

2.5. Зөвлөлийн нарийн бичгийн дарга хуралд зөвлөлийн гишүүдийн ирцийг бүрдүүлэх, хурлын тэмдэглэл хөтлөх, гаргасан шийдвэрийг баталгаажуулах, төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх ажлыг гүйцэтгэнэ.

2.6. Зөвлөлийн хурал нь 75 ба түүнээс дээш хувийн ирцтэйгээр хуралдана.

2.7. Зөвлөл нь салбарын мэргэжилтэнд зэрэг олгох мэргэшлийн хүрээ, эрхлэх ажил, үйлчилгээний чиглэл, мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг горилогчдод зориулсан сургалтын нэгдсэн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, агуулга, зөвлөх зэрэг горилох сэдвийн жагсаалт, мэргэшлийн зэрэг горилох шалгаруулалтын дүнг хэлэлцэж шийдвэрлэнэ.

Гурав. Зөвлөлийн эрх, үүрэг

3.1. Зөвлөл нь дор дурдсан эрх, үүрэгтэй. Үүнд:

3.1.1. Зөвлөл нь мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох ажиллагааг энэхүү журмын дагуу удирдан зохион байгуулна.

3.1.2. Мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг горилогчдод зориулсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг баталж, хэрэгжилтэнд хяналт тавих.

3.1.3. Шалгалтын комиссын бүрэлдэхүүнд 2-оос доошгүй зөвлөлийн гишүүн оролцох, шалгалтын комиссыг зөвлөлийн гишүүн даргалах.

3.1.4. Шалгалтын комиссын дүнг үндэслэн мэргэжлийн зэрэг олгох, буюу сунгах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, салбарын төрийн захиргааны төв байгууллагад танилцуулан баталгаажуулах

3.1.5. Холбогдох дүрэм, журмыг чанд баримтлан ашиг сонирхлын зөрчилгүйгээр, үнэнч шударга ажиллах.

3.1.6. Зөвлөл нь сургалт, шалгаруулалттай холбогдон гарсан маргаантай асуудлыг шийдвэрлэх.

Дөрөв. Сургалтын байгууллагад тавих шаардлага

4.1. Сургалтын байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна.

4.1.1. Агааржуулалт, гэрэлтүүлэг, халаалт, эрүүл ахуй, ариун цэвэр, галын аюулгүй байдал зэргийг бүрэн хангаж, суралцах таатай орчин, нөхцлийг бүрдүүлсэн байх.

4.1.2. Сургалтын анги, танхимын талбайг 40м²-аас доошгүй, нэг бүлэгт 20 суралцагч байхаар тооцож хүрэлцэхүйц анги танхимыг бэлтгэсэн байх.

4.1.3. Сургалтын онолын танхимд байвал зохих тавилга, техник хэрэгсэл, хэрэглэгдэхүүн нь зохих шаардлагыг хангасан байх;

4.1.4. Сургалт зохион байгуулах багшлах боловсон хүчин, зохих шаардлага хангасан сургалтын гарын авлага, материалтай байх.

4.1.5. Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн агуулгатай тохирсон гарын авлага, материал бүхий номын сантай байх.

Тав. Сургалтын байгууллагын эрх, үүрэг

5.1. Сургалтын байгууллага нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

5.1.1. Салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох сургалтыг зохион байгуулах байгууллага нь хүсэлтээ салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Зөвлөлд тавьж шийдвэрлүүлэх.

5.1.2. Сургалт зохион байгуулах байгууллага нь сургалтын орчин, хөтөлбөр, төлөвлөгөөгөө боловсруулж салбарын зөвлөлөөр батлуулж хэрэгжүүлэх.

5.1.3. Сургалт зохион байгуулагч байгууллага нь сургалтын тайлан, дүгнэлтээ хагас жил тутамд Зөвлөлд тайлагнаж байх.

5.1.4. Сургалт зохион байгуулагч байгууллага нь сургалттай холбоотой бичиг баримт /хөтөлбөр, хичээлийн төлөвлөгөө, суралцагчдын судалгаа, шалгалтын материал.санал хүсэлт г.м/-ыг архивын нэгж болгон 5 жил хүртэл хадгалах.

5.1.5. Сургалтын байгууллага нь мэргэжилтний мэргэшил дээшлүүлэх сургалтын талаарх төрийн бодлогыг боловсруулахад оролцох.

5.1.6. Салбарын мэргэжилтнүүдийг мэргэжил дээшлүүлэх сургалтын чиглэлээр мэргэжлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах.

Зургаа. Мэргэшлийн зэрэг горилогчид тавих шаардлага

6.1. Зэрэг горилогч, сунгах мэргэжилтэн нь энэ журмын 1 дүгээр хавсралтаар баталсан тавигдах шаардлагыг хангасан байна.

Долоо. Мэргэшлийн зэрэг горилох хүсэлт гаргах

7.1. Зэрэг горилогч нь сургалт, шалгаруулалт эхлэхээс 30 хоногийн өмнө дараах баримт, бичгийг бүрдүүлж сургалт, шалгаруулалт зохион байгуулах байгууллагад ирүүлнэ. Үүнд:

- Мэргэшлийн зэрэг олгох шалгаруулалтад хамрагдахыг хүссэн өргөдөл, анкет/ загварын дагуу/
- 3x4 хэмжээтэй 2 хувь зураг
- Мэргэжлийн дипломын баталгаажсан хуулбар
- Мэргэжил дээшлүүлсэн талаарх үнэмлэх, гэрчилгээний баталгаажсан хуулбар
- Ажил олгогчоос гадна тухайн мэргэжлийн чиглэлээр зөвлөх, тэргүүлэх зэрэгтэй 2-оос доошгүй мэргэжилтнээр баталгаажуулсан бүтээлийн тайланг загварын дагуу хавсралтаар гаргаж, боловсруулсан норм, дүрэм, стандарт, бичсэн ном, гарын авлага, нийтлэл, бүтээлийн фото хэлбэр, нүүр хуудас, гэрчилгээний хуулбар, гүйцэтгэсэн, боловсруулахад оролцсон зураг төсөл, төсвийн талаарх материалуудыг хавсаргах

7.2. Бүтээлээ худал мэдүүлэх, эсвэл бусдын бүтээлийг ашигласан нь тогтоогдвол зэрэг олгохоос татгалзана.

Найм. Мэргэшлийн зэрэгтэй мэргэжилтний эрх, үүрэг

8.1. Мэргэшлийн зэрэгтэй мэргэжилтэн нь дараах эрх эдэлж, үүргийг биелүүлнэ.

8.1.1. Мэргэшлийн зэрэгтэй мэргэжилтэн нь энэ дүрмийн 4 дүгээр хавсралтаар баталсан загвар бүхий гэрчилгээ, баталгааны тэмдэгтэй байх, дадлагашсан зэрэгтэй инженер нь баталгааны тэмдэггүй байна.

8.1.2. **Зөвлөх зэрэгтэй инженер нь** зөвхөн өөрөө гүйцэтгэсэн, оролцсон эсвэл удирдсан, хянаж зөвлөсөн ажлын гүйцэтгэлийн тайлан, дүгнэлт, техникийн акт, баримт бичиг, зураг төсөлд гарын үсэг зурж, баталгааны тэмдгээ дарж баталгаажуулах.

8.1.3. **Зөвлөх зэрэгтэй инженер нь** зөвлөх ажил үйлчилгээ үзүүлэх, зураг, төсөл, хөтөлбөр удирдан гүйцэтгэх, бусдын хийсэн ажил үйлчилгээнд хяналт тавих, шалгах, дүгнэлт гаргах.

8.1.4. **Зөвлөх зэрэгтэй инженер нь** бие даан зураг төсөл боловсруулахын зэрэгцээ бусдын боловсруулсан зураг төслийг шалгах, зам барилгын байгууламжийн зураг төсөлд магадлал хийх, сонгон шалгаруулалтад хамрагдах.

8.1.5. **Тэргүүлэх зэрэгтэй инженер нь** гэрчилгээнд заасан эрхлэх ажил үйлчилгээний хүрээнд зураг төсөл, инженерийн тооцоолол боловсруулах, судалгаа, шинжилгээ хийх, салбарын үйлдвэрлэл, үйлчилгээг зохион байгуулах, тоног төхөөрөмж угсрах, туршилт, тохируулга, зүгшрүүлэлт, засвар үйлчилгээ зэрэг ажил гүйцэтгэх, хяналт тавих.

8.1.6. **Дадлагажсан зэрэгтэй инженер нь** гэрчилгээнд заасан эрхлэх ажлын хүрээнд зураг төсөл, инженерийн тооцоолол боловсруулахад оролцох, судалгаа, шинжилгээ хийх, салбарын үйлдвэрлэл, үйлчилгээний талаар санал гаргах, тоног төхөөрөмж угсрах, туршилт, тохируулга, зүгшрүүлэлт, засвар, үйлчилгээ зэрэг ажил гүйцэтгэх,

8.1.7. **Мэргэшсэн зэрэгтэй төсөвчин нь** шинээр барих, болон өргөтгөл, шинэчлэлт, засвар хийх замын барилга байгууламжийн бизнес төлөвлөгөө хийх, зардал, өртгийг тодорхойлох, төсөв, санхүүгийн тооцоо, гүйцэтгэлийн төсөв зохиох ажлыг бие даан хийх.

8.1.8. **Тэргүүлэх зэрэгтэй төсөвчин нь** бизнес төлөвлөгөө хийхийн зэрэгцээ бусдын зохиосон бизнес төлөвлөгөөг шалгах, барилга байгууламжийн зардал, өртгийг тодорхойлох, төсөв, санхүүгийн тооцоо, гүйцэтгэлийн төсөв өртөгт магадлал хийх, бусад сонгон шалгаруулалтад хамрагдах.

8.1.9. Мэргэшлийн зэрэгтэй мэргэжилтэн нь Монгол Улсын "Хөдөлмөрийн тухай" хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу зэргийн нэмэгдэл авах. /Зөвлөх зэрэгтэй бол 20%, тэргүүлэх инженер 15%, тэргүүлэх төсөвчин 20%, мэргэшсэн төсөвчин 15%/

8.1.10. Мэргэшлийн зэрэгтэй мэргэжилтэн нь ажил үүргээ мэргэжлийн түвшинд чанартай гүйцэтгэж зэрэгтэй мэргэжилтний нэр хүндийг өргөж байхын тулд мэдлэг, ур чадвараа тасралтгүй дээшлүүлэн сургалт, шалгаруулалтын журамд заасан багц цагийг хангасан байх.

8.1.10. Мэргэшлийн зэрэгтэй мэргэжилтэн нь ажил, үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, норм стандарт, журам зааврын дагуу хариуцлагатай, чанартай хийж, гүйцэтгэх.

8.1.11. Зөвлөх, тэргүүлэх зэрэгтэй мэргэжилтэн нь салбарын чиглэлээр боловсруулж буй хууль эрх зүйн акт, норм, дүрэм, стандарт, техникийн баримт бичиг боловсруулах, санал дүгнэлт өгөх.

8.1.12. Мэргэшлийн зэрэгтэй мэргэжилтэн нь өөрийн бие дааж болон удирдан хийлгэсэн, зөвлөж, хянаж баталгаажуулсан ажлын чанар, үр дүнг бүрэн хариуцах ба өөрийн буруугаас учирсан хохирол, хариуцлагыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу бүрэн хүлээх.

8.1.14. Зөвлөх болон тэргүүлэх зэрэгтэй мэргэжилтэн нь өөрийн мэргэшлийн зэргийн хүрээнд мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг горилогчдод зориулсан сургалтад мэдээлэл хийх, зөвлөх, тэргүүлэх зэрэг горилогчийн бүтээлийн тайлан, илтгэлийн хураангуй /реферат/ хамгаалах сэдэв, төсөвт хөндлөнгийн дүгнэлт, шүүмж хийх.

8.1.15. Мэргэшлийн зэргээ цуцлуулсан мэргэжилтэн Зөвлөлд гэрчилгээ, баталгааны тэмдгийг хураалгах.

АВТО ЗАМЫН САЛБАРЫН МЭРГЭЖИЛТНИЙ МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ, МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ СУРГАЛТ, ШАЛГАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журам нь авто замын /цаашид салбар гэх/ салбарын мэргэжилтний мэдлэг боловсролын түвшин, мэргэжлийн ур чадвар, бүтээл туршлагыг үнэлэх замаар тасралтгүй мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох сургалт, шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү журмын зорилго нь салбарт ажиллаж буй инженер, төсөвчдийн мэргэжлийн ур чадварыг орчин үеийн техник, технологийн чиг хандлага, салбарын хөгжил дэвшлийн шаардлагад нийцүүлэн тасралтгүй дээшлүүлэхэд чиглэнэ.

Хоёр. Сургалт, шалгаруулалтын удирдлага зохион байгуулалт

- 2.1. Салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах сургалт, шалгалтыг Зөвлөлөөс баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулна.
- 2.2. Салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах сургалт, шалгалтыг төлөвлөж, хэрэгжүүлэх, сургалтын нэгдсэн хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, сургалт бүрийн хөтөлбөрийг боловсруулах үйл ажиллагаанд салбарын төрийн болон мэргэжлийн төрийн бус байгууллагууд, зөвлөх, тэргүүлэх зэрэгтэй мэргэжилтнүүдийг татан оролцуулна.

Гурав. Сургалт зохион байгуулах үйл ажиллагаа

- 3.1. Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь сургалтын байгууллагуудтай хамтран салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, сунгах сургалтын нэгдсэн хөтөлбөрийг жил тутам шинэчлэн баталж хэрэгжүүлнэ.
- 3.2. Нэгдсэн хөтөлбөрт салбарын мэргэжилтнүүдэд зориулсан дадлагажуулах, мэргэшүүлэх сургалт болон тодорхой сэдвээр явагдах урт, богино хугацааны чадавхижуулах сургалтын төрлийг тогтоох ба эдгээр сургалтын чиглэл, сэдэв, сургалт явуулах хэлбэр, хугацааг нарийвчлан тусгана.
- 3.3. Нэгдсэн хөтөлбөрт тусгагдсан аливаа сургалтыг агуулга, сэдвийн хувьд мэргэшүүлэх, чадавхижуулах гэсэн хоёр чиглэлээр явуулна.
- 3.4. Салбарын мэргэжилтэн бүр мэргэжлийн чиглэлээр жил бүр 3 доошгүй багц цаг хангахуйц мэргэшүүлэх болон чадавхижуулах сургалтанд хамрагдсан байна.

Дөрөв. Сургалтын хөтөлбөр

- 4.1. Сургалт зохион байгуулах байгууллага нь зохион байгуулахаар төлөвлөж буй сургалт бүрийн хөтөлбөрийг Зөвлөлөөр хэлэлцүүлнэ.

- 4.2. Сургалтын хөтөлбөрт сургалтын нэр, зорилго, зорилт, төрөл, чиглэл, цагийн багтаамж, олгогдох багц цаг, сургалт зохион байгуулах байршил болон хугацаа, сургалтад хамрах мэргэшлийн хүрээ, сургалтын товч агуулга, сургалтын үед ашиглах гарын авлага, тараах материал, суралцагчийн мэдлэг чадварыг сорих бодлого, дасгал, асуулт, хариултын хамт тусгасан байна.
- 4.3. Дадлагажуулах нэг сургалтын хөтөлбөр нь 2 багц цагаас доошгүй, 6 багц цагаас илүүгүй хэмжээний багтаамжтай байх ба урт хугацааны сургалтын хувьд хөтөлбөрийг сэдвийн хувьд хэсэгчлэн баталж болно.
- 4.4. Мэргэшүүлэх нэг сургалтын хөтөлбөр нь 4 багц цагаас багагүй хэмжээний багтаамжтай байна.
- 4.5. Сургалтын хөтөлбөр нь салбарын мэргэжилтний суралцах, мэдлэг, чадвар, мэргэжлээ дээшлүүлэх эрэлт хэрэгцээнд түшиглэсэн байх ба агуулгын хувьд онолын мэдлэгээс гадна суралцагсдад дадлагын ур чадвар олгоход чиглэсэн байна.

Тав. Мэргэжил дээшлүүлэх, бүтээлийг үнэлэх, багц цаг тооцох

- 5.1. Салбарын мэргэжилтний мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох сургалтын багц цагийг танхимын хичээл болон танхимын бус үйл ажиллагааны хэлбэрээр хангаж болно. Дадлагажсан, мэргэшсэн зэрэгтэй мэргэжилтэн нь танхимын бус хэлбэрээр, зөвлөх, тэргүүлэх зэрэгтэй мэргэжилтэн нь танхимын сургалтын хэлбэрээр нийт багц цагийн тус тус 30-аас доошгүй хувийг хангасан байна.
- 5.2. Мэргэшүүлэх сургалтын танхимын хичээлийн 16 цагийг сургалтын 1 багц цаг, дадлагажуулах сургалтын танхимын хичээлийн 32 цагийг сургалтын 1 багц гэж тооцно.
- 5.3. Мэргэжилтэн нь танхимын хичээлд биечлэн бүрэн оролцсон тохиолдолд тухайн хөтөлбөрт заасан багц цагийг хангасанд тооцно.
- 5.4. Зэрэг горилогч нь бүтээлийн тайланг Загвар №1-ийн дагуу, зэрэг сунгах болон ахиулах мэргэжилтэн нь зэрэг авснаас хойш хийсэн бүтээлийн тайланг мэргэжил дээшлүүлсэн бодит цагийн хэмжээгээр тооцож, Загвар №2-ын дагуу гарган нотлох баримт материалыг хавсаргана.

Загвар №1

.....овогтой..... бүтээлийн тайлан

№	Бүтээлийн нэр	Гүйцэтгэсэн хугацаа, он, сар	Өөрөө гүйцэтгэсэн, оролцсон, хэрэгжүүлсэн аль нь болох	Шийдвэр гаргасан, баталгаажуулсан байгууллага, албан тушаалтан

Тайланг бичсэн зэрэг горилогч:

/

/

Хянаж баталгаажуулсан:

/

/

..... ОВОГТОЙ.....-ний мэргэжил дээшлүүлсэн тайлан

№	Мэргэжил дээшлүүлсэн хэлбэр,	Хугацаа он, сар, өдөр	Бодит цагийн хэмжээ	Багц цагт шилжүүлсэн

Тайланг бичсэн зэрэг горилогч: / /
Хянаж баталгаажуулсан: / /

- 5.5. Салбарын мэргэжилтний мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох сургалтын багц цагийг танхимын бус дараах хэлбэрийн үйл ажиллагаагаар хангаж болно. Үүнд:
- а. Салбарын чиглэлээр хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандартын төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан ба тухайн баримт бичиг нь батлагдсан бол 4 багц цаг;
 - б. Салбарын чиглэлийн хууль эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандартад санал өгч тусгуулсан, шүүмж хийсэн бол 1 багц цаг;
 - в. Мэргэжлийн заавар, зөвлөмж, гарын авлага гаргасан бол 5 багц цаг;
 - г. Мэргэжлийн ном, нэг сэдэвт бүтээл нийтлүүлсэн бол 10 багц цаг;
 - д. Мэргэжлийн сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлүүлсэн бол нэг өгүүлэл тухайн сэдвийн чиглэлээр 2 багц цаг;
 - е. Магистрын зэрэг хамгаалсан бол хамгаалсан сэдвийн чиглэлээр 10 багц цаг;
 - ё. Докторын зэрэг хамгаалсан бол хамгаалсан сэдвийн чиглэлээр 30 багц цаг;
 - ж. Салбарын чиглэлээр төсөл, хөтөлбөр боловсруулах, судалгаа хийх ажлын хэсэгт ажиллаж, ажлын тайлан, илтгэлийг нийтлүүлсэн бол тайлан тус бүрээр 4 багц цагийг ажилласан хүний тоогоор хувь тэнцүүлэн;
 - з. Шинээр бэлтгэсэн илтгэл, хичээлийн лекц /Заасан сэдвийн чиглэлээр хичээлийн 4 цаг тутамд 1 багц цаг/;
 - и. Их, дээд сургууль төгсөгчийн дипломын ажил удирдсан /1 оюутан-0.5 багц цаг/;
 - к. Шалгалтын асуулт, тест боловсруулсан /багц бүр нь 20 асуулт бүхий 10 багц тест - 0,5 багц цаг/;
 - л. Шалгалтын комиссын бүрэлдэхүүнд орж ажилласан /1 удаа-0,5 багц цаг/.
- 5.6. Мэргэжилтэн нь танхимын бус хэлбэрээр багц цаг хангасан тодорхойлолтыг өөрөө гаргаж, зохих нотлох баримтын хамт салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад жил бүр ирүүлж байна. Зөвлөл нь танхимын бус хэлбэрээр багц цаг олгох асуудлыг жил бүр хэлэлцэн шийдвэрлэж хариу мэдэгдэнэ.
- 5.7. Мэргэжилтэн нь мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг горилох, сунгах сургалтад хамрагдсан болон сургалтын багц цаг хангасан талаархи өөрийн мэдээлэл, бүртгэлтэй танилцах, лавлагаа авах, буруу мэдээллийг өөрчлөх, засвар оруулахыг шаардах эрхтэй.

Зургаа. Мэргэжлийн зэрэг олгох шалгалтын ажиллагаа

- 6.1 Сургалтын байгууллага нь мэдлэгийн түвшин, мэргэжлийн ур чадварыг шалгалтаар, бүтээл, туршлагыг ажил байдлын тодорхойлолт, бүтээлийн тайланг зохих журмын дагуу магадлан шалгах замаар тодорхойлно.
- 6.2 Сургалтын байгууллага нь мэргэшлийн зэрэг олгох сургалт, шалгалт зохион байгуулах хугацааг баталгаажуулан тухайн оны эхэнд олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлаж мэдэгдэнэ.
- 6.3 Мэргэшлийн зэрэг олгох шалгалт нь инженерийн хувьд дадлагажсан зэрэг горилогч нэг, тэргүүлэх зэрэг горилогч хоёр, зөвлөх зэрэг горилогч гурван үе шаттай, төсөвчний хувьд мэргэшсэн зэрэг горилогч хоёр, тэргүүлэх зэрэг горилогч гурван үе шаттайгаар явагдана. Үүнд:
 - а. Нэгдүгээр шат. Мэргэжлийн шалгалт /мэргэжлийн чиглэлийн мэдлэг, ур чадвар болон салбарын хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандарт, журам, зааврын талаарх мэдлэгийг шалгах/
 - б. Хоёрдугаар шат. Бүтээлийн тайлан хамгаалах
 - в. Реферат бичиж хамгаалах
- 6.4 Дадлагажсан зэрэг горилогч нь мэргэшлийн болон мэргэжлийн ур чадварын шалгалтад авбал зохих нийт онооны 80 буюу түүнээс дээш хувь, тэргүүлэх, мэргэшсэн зэрэг горилогч нь 85 буюу түүнээс дээш, зөвлөх зэрэг горилогч нь 90 буюу түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн бол тэнцсэнд тооцно.
- 6.5 Мэргэжлийн шалгалтыг бичгээр, тест, зураг тооцоо, загвар зэргээр авна.
- 6.6 Мэргэжлийн хүрээний чиглэлээр докторын зэрэг хамгаалсан тохиолдолд зөвлөх, тэргүүлэх зэрэг горилогчийн бичгээр уламжилсан хүсэлтийг үндэслэн зөвхөн мэргэшлийн шалгалтаас чөлөөлж болно.
- 6.7 Зэргийн хугацаагаа сунгуулж буй мэргэжилтэн нь өөрийн мэргэжлийн чиглэлээр норм, дүрэм, стандарт, техникийн баримт бичиг боловсруулсан болон санал, шүүмж, дүгнэлтийг мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн материалаа мэдээллийн сан болон архивын нэгж болгон хадгалуулсан байна. Энэхүү санал, дүгнэлтээ тайлан хамгаалалтад бүрдүүлэх материалд хавсаргасан байна.
- 6.8 Эхний шатны шалгаруулалтад тэнцээгүй зэрэг горилогч нь дараагийн шатны шалгаруулалтад орох эрхгүй болно.
- 6.9 Шалгалтын комисс нь зэрэг горилогчийн шалгалтын дүн, бүтээл, туршлагад үндэслэн зэрэг олгох саналаа Салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгох орон тооны бус Зөвлөлд оруулж шийдвэрлүүлнэ.
- 6.10 Мэргэшлийн шалгалтыг бичгээр болон тестээр, тайлан хамгаалалт болон ур чадварын шалгалтыг тухайн горилогчийн мэргэжлийн хүрээнд гүйцэтгэсэн ажлын бүтээл, ур чадварын түвшинг ярилцлагын хэлбэрээр авна.
- 6.11 Зөвлөх зэрэг горилогчийн илтгэл/реферат/-ийг салбарын тухайн мэргэжлийн чиглэлийн зөвлөх зэрэгтэй болон эрдмийн зэрэг цолтой мэргэжилтнээр шүүмжлүүлсэн байна. Комиссын бүрэлдэхүүн болон илтгэл/реферат/-ийн шүүмжлэгчийг горилогчоос, горилогчийг шүүмжлэгчээс тус тус нууцална.
- 6.12 Шалгалтын тест, бодлого, өгөгдлийг тестийн сангаас сонгох бөгөөд энэ нь шалгалт авах өдөр, цаг хүртэл байгууллагын нууцад хамаарна.
- 6.13 Зэрэг горилогчийн авсан нийт онооны нийлбэрийг шалгалтын комиссын нарийн бичгийн дарга нэгтгэн дүгнэж, дундаж оноог гаргах ба комиссын дарга энэ дүнг комиссын гишүүдийн хурлаар хэлэлцүүлэн гишүүн бүрээр гарын үсэг зуруулж баталгаажуулна.
- 6.14 Зэрэг горилогч нь сэдвийн хамгаалалтын материалаа товлосон хугацаанаас 14 хоногийн өмнө тухайн сургалт хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгсөн байна.
- 6.15 Комиссын гишүүд нь горилогчийн сэдвийн хамгаалалтын материалтай

- хамгаалалтаас өмнө нэг бүрчлэн танилцсан байна.
- 6.16 Комиссын гишүүд горилогчийн илтгэл, тайланг түүний онол, техник технологийн түвшин, мэдээлэл тусгалт, үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломж, нэвтрүүлсэн байдал, шинэлэг санаа, ач холбогдол, асуултад хариулсан байдал, шүүмжийн үнэлгээ зэрэг үзүүлэлтээр дүгнэж болно.
- 6.17 Комиссын нарийн бичгийн дарга нь шалгалтын нэгдсэн дүн, холбогдох материалыг цэгцэлж шалгалт дууссанаас хойш нэг сарын дотор Зөвлөлийн гишүүн бүрд хүргүүлнэ.
- 6.18 Шалгалтын үнэлгээн дээр маргаантай асуудал гарвал горилогч нь гомдол, саналаа Зөвлөлд бичгээр тавьж шийдвэрлүүлнэ. Энэ шийдвэр эцсийн шийдвэр байна.
- 6.19 Шалгалтын үйл ажиллагаанд хөндлөнгийн хянагчаас гадна мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгч хяналт тавьж болно.
- 6.20 Мэргэшлийн зэрэг горилогч нь шалгаруулалтад тэнцээгүй бол дахин шалгаруулалтад оролцох хүсэлтээ бичгээр гаргасны үндсэн дээр шалгаруулалтад оролцож болно.

Долоо. Зөвлөх инженерийн зэрэг горилох сэдвийн илтгэлийн хураангуй /реферат/

- 7.1 Илтгэлийн хураангуй нь барилга, зам, хот байгуулалт, зураг төсөл, барилгын материалын үйлдвэрлэл, газрын харилцааны салбарт шинэ техник, дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйлдвэрлэлийн удирдлага, зохион байгуулалт, өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэгдсэн, шинжилгээ судалгаа бүхий онол практикийн бага хурлын илтгэлийн хэмжээнд бичигдсэн, тодорхой асуудал дэвшүүлж шийдвэрлэх арга замыг заасан байвал зохино.
- 7.2 Илтгэлийн хураангуйг 15-25 хуудсанд /Arial 12/ багтаан бичиж, мэргэжлийн шалгалтын комиссоос оноож өгсөн салбарын тэргүүлэх /эрдэмтэд, зөвлөх/ мэргэжилтнээр шүүмжлүүлсэн байна.
- 7.3 Илтгэлийн хураангуй бичих чиглэлийг дараах байдлаар сонгоно.
- Баталсан сэдвийн жагсаалтаас сонгох
 - Шалгалтын комиссоос зөвшөөрсөн сэдвээр
 - Шалгалтын комиссоос оноож өгсөн сэдвээр
- 7.4 Илтгэлийн товчлолыг зохиогчийн зөвшөөрөлтэйгээр нийтийн хүртээл болгож болно.
- 7.5 Илтгэлийн хураангуй нь оршил, асуудлын судлагдсан байдал, судалгаа боловсруулалт, хэрэгжүүлэлт, туршилт, тухайн ажлын үр дүн, санал дүгнэлт, ашигласан материал, хавсралтаас бүрдэнэ.
- 7.6 Оршил: Зөвлөх инженерийн зэрэг горилж буй сэдвийн үндэслэл, ач холбогдол, түүний шинэлэг талын тухай болон илтгэлийн ерөнхий байдлыг товч дүгнэж бичнэ. Энэ сэдвээр зэрэг горилогч ямар зүйл бүтээсэн, туршсан, үйлдвэрлэлд нэвтрүүлсэн /зураг төсөл, норм, норматив, заавар, журам, машин техник, технологи, удирдлагын арга барил, ном зохиол, шинэ бүтээл, тэргүүн туршлага гэх мэт/ энэ нь ямар асуудал шийдвэрлэснийг дурдана.
- 7.7 Асуудлын судлагдсан байдал: тухайн сэдвээр гадаадын улс орнууд болон манай оронд судалсан байдал, онолын үндэслэл, ямар үр дүнд хүрснийг бичнэ. Мөн судалгаа шинжилгээ, үйлдвэрлэл, туршилтын ямар арга хэрэглэж юу зохион бүтээсэн, түүний өөрийн орны урьд нь байсан үйлдвэрлэлийн үзүүлэлт, болон хөгжингүй орны техник эдийн засгийн үзүүлэлттэй харьцуулсан судалгаа, дүгнэлт хийсэн байна.
- 7.8 Судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлт, туршилт: энэ сэдвээр явуулсан судалгаа, туршилтын ажил болон үйлдвэрлэлд нэвтрүүлснээр гарсан бодит үр дүнг биет болон тоон үзүүлэлтээр гаргах, түүний нийгэм, эдийн засгийн ач

- холбогдол, тулгамдсан ямар асуудлыг шийдвэрлэсэн буюу шийдвэрлэхэд тус дөхөм үзүүлсэнийг тодорхой тусгана.
- 7.9 Ажлын үр дүн: энэ сэдвээр гаргасан шинэ санаа, эсвэл онцлог шинэлэг зүйл юу байгаа, цаашид үйлдвэрлэл, практикт нэвтрүүлэх эрх зүйн орчин түүхий эд, технологи, машин механизм, тоног төхөөрөмж, ажиллах боловсон хүчний хангамжийн асуудал учирч болох бэрхшээл, шийдэх тулгамдсан асуудлууд зэргийг бичнэ.
- 7.10 Санал, дүгнэлт: энэ асуудал олон улсын болон хөгжилтэй орны хэмжээнд ямар байгаа, манай орны нөхцөлд шийдвэрлэх, хэрэгжүүлэхэд гарч болох төвөгшилтэй маргаантай асуудлууд юу байгаа, тэдгээрийг ямар арга замаар хэрхэн шийдвэрлэх тухай өөрийн үзэл бодлоо үндэслэл, тооцоотой гаргана.
- 7.11 Ашигласан хэвлэл, материал: сэдвийг боловсруулахад ашигласан гадаад, дотоодын хэвлэл, сурах бичиг, норм дүрэм, заавар журам, интернетийн мэдээллийг жагсааж бичнэ. Ашигласан материал нь илтгэлийн хураангуй дотор заавал иш татагдсан эсвэл дугаараараа заагдсан байна.
- 7.12 Хавсралт: Сэдвийн судалгаа, туршилтын үр дүн түүнд холбогдох хүснэгт, график зураг, үзүүлэн материалыг хавсаргана. Мөн сэдвийн хамгаалалтын дүн хэрэглэх зарим биет үзүүлэн, загвар, альбом байж болно. Хавсралт материалын тоо хэмжээнд тодорхой хязгаарлалт байхгүй бөгөөд энэ нь рефератын ерөнхий хэмжээнд орохгүй.
- 7.13 Рефератын нүүр нь төрийн захиргааны байгууллага, сургалт зохион байгуулсан байгууллага, горилогчийн нэр, шүүмжлэгчийн нэр, зэрэг, албан тушаал зэргийг агуулсан байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын
2017 оны дугаар сарын ... ны
өдрийн ... тушаалын гуравдугаар
хавсралт

**АВТО ЗАМЫН САЛБАРЫН МЭРГЭЖИЛТЭНД
МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ХҮРЭЭ**

1. Авто замын зураг төслийн инженер:
 - 1.1 авто замын төсөллөлтийн
 - 1.2 авто замын гүүр, тоннелын төсөллөлтийн
2. Авто замын инженер:
 - 2.1 авто замын барилгын
 - 2.2 авто замын гүүр, тоннелийн
 - 2.3 авто замын засвар, арчлалтын
3. Материалын инженер:
 - 3.1 авто зам, замын байгууламжийн материалын
4. Замын машин, тоног төхөөрөмж:
 - 4.1 авто замын машин, тоног төхөөрөмжийн
5. Авто зам, гүүрийн барилгын төсөвчин
 - 5.1 авто зам, гүүрийн барилгын төсөвчин
6. Авто замын эдийн засаг, менежмент
7. Зам, замын байгууламжийн геодезийн хэмжилт

Авто замын салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх,
мэргэжлийн зэрэг олгох журмын нэгдүгээр хавсралт

Салбарын мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, мэргэшлийн зэрэг олгоход тавигдах шаардлага

Мэргэжил	Мэргэшлийн зэрэг олгох мэргэжилтэнд тавигдах шаардлага	Мэргэжлийн зэрэг олгох шалгаруулалтын үйл ажиллагааны үе шат	Мэргэжлтний мэргэшлийн зэргийг сунгах, ахиулах, цуцлах үе шат
----------	--	--	---

1.8. Мэргэжилтэн гэдэгт авто зам, гүүр, замын бусад байгууламжийн барилга, засвар арчлалт, материалын үйлдвэрлэл, замын хяналт, зам гүүрийн зураг төслийн инженерүүд, зам, гүүрийн барилга, засварын машин механизм, бутлуур, заводын болон бусад тоног төхөөрөмжийн мехатроникийн инженер, Авто замын гэрээ, тоо хэмжээний мэргэжилтнүүд хамаарна.

Зам, гүүрийн инженер	Дадлагдажсан	боловсрол	Төрөөс баримтлах боловсролын стандартыг хангасан их, дээд сургууль, коллеж төгсөж дипломын болон бакалаврын боловсрол эзэмшсэн байх	1.Мэргэжилтний бүтээл туршлагыг магадлан үнэлэх /Загварын дагуу гаргасан бүтээлийн тайланг хянан магадлана./ 2. Мэргэжлийн болон ур чадварын шалгалт нь /салбарын хууль, эрх зүйн баримт бичиг, норм норматив,стандарт, дүрэм, журам, заавар/ мэдлэгийг шалгах тест байх ба авбал зохих нийт онооны 80 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд тэнцсэнд тооцно	Дадлагдажсан зэрэгтэй инженер нь 3 жилийн дараа зэргээ сунгаж баталгаажуулах ба 2 дахь сунгалтаас гэрчилгээнд хугацаа заахгүй	Зэрэг сунгах үйл явц	Зэргээ сунгуулах хүсэлтийг зэрэг авснаас хойшхи хугацаанд хийсэн ажил болон мэргэжил дээшлүүлсэн талаархи тайлан, тодорхойлолтын хамт зэргийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө зөвлөлд ирүүлнэ. Дадлагдажсан зэргийн хугацаагаа сунгуулахдаа: <ul style="list-style-type: none"> Өөрийн биеэр ирж хийсэн ажлаа шалгалтын комисст тайлагнана
		Ажилласан жил	Дипломын боловсрол эзэмшснээс хойш мэргэжлээрээ 4- өөс дээш жил тасралтгүй үр бүтээлтэй, үүнээс 3 жил нь үйлдвэрлэл дээр ажилласан байх Бакалавр зэрэгтэй бол 3 - аас дээш жил мэргэжлээрээ тасралтгүй үр бүтээлтэй, үүнээс 2 жил нь зам, гүүрийн үйлдвэрлэлд ажилласан байх				Дадлагдажсан зэргийн хугацаа сунгуулахад биеэр ирж ажлаа шалгалтын комисст тайлагнах ба 80 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд сунгана.

Зам, гүүрийн инженер	Тэргүүлэх	боловсрол	Төрөөс баримтлах боловсролын стандартыг хангасан их дээд сургууль төгсөж бакалаврын боловсрол эзэмшсэн байх	1.Мэргэжилтний бүтээл туршлагыг магадлан үнэлэх /Загварын дагуу гаргасан бүтээлийн тайланг хянан магадлана./	Тэргүүлэх зэрэгтэй мэргэжилтэн нь 3 жил тутамд зэргээ сунгаж баталгаажуулах ба 3 дахь сунгалтаас хойш хугацаагүй сунгаж болно.	Зэрэг сунгах үйл явц	Зэргээ сунгуулах хүсэлтийг зэрэг авснаас хойшхи хугацаанд хийсэн ажил болон мэргэжил дээшлүүлсэн талаархи тайлан, байгууллагын тодорхойлолтын хамт зэргийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө зөвлөлд ирүүлнэ. Тэргүүлэх зэргийн хугацаагаа сунгуулахдаа: <ul style="list-style-type: none"> • Өөрийн биеэр ирж бүтээлээ шалгалтын комисст тайлагнана • Мэргэжлийн чиглэлээрээ 1-ээс доошгүй хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандарт боловсруулахад заавал оролцсон,хянан тохиолдуулсан, санал өгч тусгуулсан, заавар, зөвлөмж, гарын авлага гаргасан байх 		
		Ажилласан жил	Бакалавр зэрэгтэй бол 5 - аас дээш жил мэргэжлээрээ тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх, дадлагажсан инженерийн зэрэгтэй болсон байх, Гүйцэтгэгч байгууллагад тогтвортой 4 жил ажилласан байх	2.Салбарын мэргэжлийн сэтгүүл, хэвлэлд асуудал дэвшүүлсэн өгүүлэл, мэргэжлийн холбогдолтой зйл 1-ээс доошгүй бичсэн байх			Тэргүүлэх зэрэгтэй мэргэжилтэн нь 3 жил тутамд зэргээ сунгаж баталгаажуулах ба 3 дахь сунгалтаас хойш хугацаагүй сунгаж болно.	Зэрэг сунгах үйл явц	Тэргүүлэх зэргийн хугацаа сунгуулахад биеэр ирж бүтээлээ шалгалтын комисст тайлагнах ба 85 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд сунгана.
			Магистрын зэрэгтэй бол 4 - өөс дээш жил мэргэжлээрээ тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх, дадлагажсан инженерийн зэрэгтэй болсон байх, Гүйцэтгэгч байгууллагад тогтвортой 3 жил ажилласан байх	3.Мэргэжлийн болон ур чадварын шалгалт нь /салбарын хууль, эрх зүйн баримт бичиг, норм норматив,стандарт, дүрэм, журам, заавар мэдлэгийг шалгах тест байх ба авбал зохих нийт онооны 85 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд тэнцсэнд тооцно.					

Зам, гүүрийн инженер	Зөвлөх	Боловсрол	Төрөөс баримтлах боловсролын стандартыг хангасан их дээд сургууль төгсөж бакалаврын боловсрол эзэмшсэн, магистрын зэрэгтэй байх	1.Мэргэжилтний бүтээл туршлагыг магадлан үнэлэх /Загварын дагуу гаргасан бүтээлийн тайланг хянан магадлана./ 2.Мэргэжлийн болон ур чадварын шалгалт нь /салбарын хууль, эрх зүйн баримт бичиг, норм норматив,стандарт, дүрэм, журам, заавар/ мэдлэгийг шалгах тест байх ба авбал зохих нийт онооны 90 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд тэнцсэнд тооцно.	Зөвлөх зэрэгтэй мэргэжилтэн нь 5 жил тутамд зэргээ сунгуулах ба 3 дахь сунгалтаас хугацаагүй болгоно.	Зэрэг сунгуулах үйл явц	Зэргээ сунгуулах хүсэлтийг зэрэг авснаас хойшхи хугацаанд хийсэн ажил болон мэргэжил дээшлүүлсэн талаархи тайлан, тодорхойлолтын хамт зэргийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө зөвлөлд ирүүлнэ. Зөвлөх зэргийн хугацаагаа сунгуулахдаа: <ul style="list-style-type: none"> • Өөрийн биеэр ирж ажлаа шалгалтын комисст тайлагнана Тэргүүлэх зэргээ зөвлөх зэрэгт ахиулахдаа: <ul style="list-style-type: none"> • Тэргүүлэх зэргээ зөвлөх зэрэгт ахиулах хүсэлт гаргасан бол зэрэг сунгах бүтээлээрээ тайлан хамгаалалтад орж тэнцсэн байна. • Мэргэжлийн ур чадварын мэдлэгийг шалгах тестийн шалгалтанд авбал зохих нийт онооны 90 буюу түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн байх • Сэдвийн хамгаалалтад 80 буюу түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн байна.
		Ажилласан жил	Тэргүүлэх инженерийн зэрэг авснаас хойш мэргэжлээрээ 9 ба түүнээс дээш жил тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх	3. Сонгосон буюу оноож өгсөн сэдвээр реферат бичиж, хамгаалан 80 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд тэнцсэнд тооцно.			
		Бусад шаардлага	Мэргэжлийн хүрээний чиглэлээр доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан тохиолдолд Зөвлөх зэрэг горилогчийн бичгээр уламжилсан хүсэлтийг үндэслэн зөвхөн мэргэжлийн шалгалтаас чөлөөлөх	4. Авто замын салбарын холбогдолтой эрдэм, шинжилгээ, судалгаа, инновацийн чиглэлээр 3-аас доошгүй материал салбарын хэвлэлд нийтлүүлсэн байх			

Зам, гүүрийн машин механизм, тоног төхөөрөмжийн механик инженер	Дадлагажсан	боловсрол	Төрөөс баримтлах боловсролын стандартыг хангасан их, дээд сургууль, коллеж төгсөж дипломын болон бакалаврын боловсрол эзэмшсэн байх	1.Мэргэжилтний бүтээл туршлагыг магадлан үнэлэх /Загварын дагуу гаргасан бүтээлийн тайланг хянан магадлана./ 2. Мэргэжлийн болон ур чадварын шалгалт нь /салбарын хууль, эрх зүйн баримт бичиг, норм норматив,стандарт, дүрэм, журам, заавар мэдлэгийг шалгах тест байх ба авбал зохих нийт онооны 80 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд тэнцсэнд тооцно	Дадлагажсан зэрэгтэй инженер нь 3 жилийн дараа сунгаж баталгаажуулах ба 2 дахь сунгалтаас гэрчилгээнд хугацаа заахгүй	Зэрэг сунгах үйл явц	Зэргээ сунгуулах хүсэлтийг зэрэг авснаас хойшхи хугацаанд хийсэн ажил болон мэргэжил дээшлүүлсэн талаархи тайлан, тодорхойлолтын хамт зэргийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө зөвлөлд ирүүлнэ. Дадлагажсан зэргийн хугацаагаа сунгуулахдаа: <ul style="list-style-type: none"> • Өөрийн биеэр ирж ажлаа шалгалтын комисст тайлагнана
		Ажилласан жил	Дипломын дээд боловсрол эзэмшснээс хойш мэргэжлээрээ 4- өөс дээш жил тасралтгүй үр бүтээлтэй, үүнээс 3 жил нь үйлдвэрлэл, талбайд техниктэй шууд харьцан ажилласан байх				Дадлагажсан зэргийн хугацаа сунгуулахад биеэр ирж ажлаа шалгалтын комисст тайлагнах ба 80 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд сунгана.
			Бакалавр зэрэгтэй бол 3 - аас дээш жил мэргэжлээрээ тасралтгүй үр бүтээлтэй, үүнээс 2 жил нь зам, гүүрийн үйлдвэрлэл, талбайд техниктэй шууд харьцан ажилласан байх				

Зам, гүүрийн машин механизм, тоног төхөөрөмж механик инженер	Тэргүүлэх	боловсрол	Төрөөс баримтлах боловсролын стандартыг хангасан их дээд сургууль төгсөж бакалаврын боловсрол эзэмшсэн байх	1.Мэргэжилтний бүтээл туршлагыг магадлан үнэлэх /Загварын дагуу гаргасан бүтээлийн тайланг хянан магадлана./	Тэргүүлэх зэрэгтэй мэргэжилтэн нь 3 жил тутамд зэргээ сунгаж баталгаажуулах ба 3 дахь сунгалтаас хойш хугацаагүй сунгаж болно.	Зэрэг сунгах үйл явц	Зэргээ сунгуулах хүсэлтийг зэрэг авснаас хойшхи хугацаанд хийсэн ажил болон мэргэжил дээшлүүлсэн талаархи тайлан, тодорхойлолтын хамт зэргийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө зөвлөлд ирүүлнэ. Тэргүүлэх зэргийн хугацаагаа сунгуулахдаа: <ul style="list-style-type: none"> • Өөрийн биеэр ирж бүтээлээ шалгалтын комисст тайлагнана • Мэргэжлийн чиглэлээрээ 1-ээс доошгүй хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандарт боловсруулахад заавал оролцсон,хянан тохиолдуулсан, санал өгч тусгуулсан, заавар, зөвлөмж, гарын авлага гаргасан байх
		Ажилласан жил	Бакалавр зэрэгтэй бол 5 - аас дээш жил мэргэжлээрээ тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх, дадлагажсан инженерийн зэрэгтэй болсон байх, 3-аас доошгүй жил техникийн тохируулга, зүгшрүүлэлтийг гардан хийсэн байх	2.Салбарын мэргэжлийн сэтгүүлд асуудал дэвшүүлсэн өгүүлэл, мэргэжлийн холбогдолтой зүйл 1-ээс доошгүй бичсэн байх			Зэргээ сунгуулахдаа: <ul style="list-style-type: none"> • Өөрийн биеэр ирж бүтээлээ шалгалтын комисст тайлагнах ба 85 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд сунгана.
			Магистрын зэрэгтэй бол 4 - өөс дээш жил мэргэжлээрээ тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх, дадлагажсан инженерийн зэрэгтэй болсон байх, 3-аас доошгүй жил техникийн тохируулга, зүгшрүүлэлтийг гардан хийсэн байх	3.Мэргэжлийн болон ур чадварын шалгалт /салбарын хууль, эрх зүйн баримт бичиг, норм норматив,стандарт, дүрэм, журам, заавар/ мэдлэгийг шалгах тест байх ба авбал зохих нийт онооны 85 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд тэнцсэнд тооцно.			

Зам, гүүрийн машин механизм, тоног төхөөрөмжийн механик инженер	Зөвлөх	Боловсрол	Төрөөс баримтлах боловсролын стандартыг хангасан их дээд сургууль төгсөж боловсрол эзэмшсэн байх, магистрын зэрэгтэй байх	1.Мэргэжилтний бүтээл туршлагыг магадлан үнэлэх /Загварын дагуу гаргасан бүтээлийн тайланг хянан магадлана./ 2.Мэргэжлийн болон ур чадварын шалгалт /салбарын хууль, эрх зүйн баримт бичиг, норм норматив,стандарт, дүрэм, журам, заавар/ мэдлэгийг шалгах тест байх ба авбал зохихнийт онооны 90 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд тэнцсэнд тооцно.	Зөвлөх зэрэгтэй мэргэжилтэн нь 5 жил тутамд зэргээ сунгуулах ба 3 дахь сунгалтаас хугацаагүй болно.	Зэргээ сунгуулах үйл явц	Зэргээ сунгуулах хүсэлтийг зэрэг авснаас хойшхи хугацаанд хийсэн ажил болон мэргэжил дээшлүүлсэн талаархи тайлан, тодорхойлолтын хамт зэргийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө зөвлөлд ирүүлнэ. Зөвлөх зэргийн хугацаагаа сунгуулахдаа:
		Ажилласан жил	Тэргүүлэх инженерийн зэрэг авснаас хойш мэргэжлээрээ 9 ба түүнээс дээш жил тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх, 2-оос доошгүй орчин үеийн шинэ техникийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, зам барилгын технологийн үндсэн техникуудийн тохиргоо, зүгшрүүлэлтийг гардан гүйцэтгэх буюу гүйцэтгэлд нь хяналт тавих дадлагыг бүрэн эзэмшсэн байх	3. Сонгосон буюу оноож өгсөн сэдвээр реферат бичиж, хамгаалан 80 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд тэнцсэнд тооцно.			<ul style="list-style-type: none"> Өөрийн биеэр ирж бүтээлээ шалгалтын комисст тайлагнана Тэргүүлэх зэргээ зөвлөх зэрэгт ахиулахдаа:
		Бусад шаардлага	Мэргэжлийн хүрээний чиглэлээр доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан тохиолдолд Зөвлөх зэрэг горилогчийн бичгээр уламжилсан хүсэлтийг үндэслэн зөвхөн мэргэжлийн шалгалтаас чөлөөлөх	4. Авто замын машин, тоног төхөөрөмжийг автоматжуулах болон инновацийн чиглэлээр 3-аас доошгүй материал салбарын хэвлэлд нийтлүүлсэн байх			<ul style="list-style-type: none"> Тэргүүлэх зэргээ зөвлөх зэрэгт ахиулах хүсэлт гаргасан бол зэрэг сунгах бүтээлээрээ тайлан хамгаалалтад орж тэнцсэн байна. Мэргэжлийн ур чадварын мэдлэгийг шалгах тестийн шалгалтанд авбал зохих нийт онооны 90 буюу түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн байх Сэдвийн хамгаалалтад 80 буюу түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн байна.

Авто замын салбарын төсөвчин	Мэргэшсэн	боловсрол	Төрөөс баримтлах боловсролын стандартыг хангасан их дээд сургууль төгсөж бакалаврын боловсрол эзэмшсэн.	1.Мэргэжилтний бүтээл туршлагыг магадлан үнэлэх /Загварын дагуу гаргасан бүтээлийн тайланг хянан магадлана./	Мэргэшсэн зэрэгтэй мэргэжилтэн нь 3 жил тутамд зэргээ сунгаж баталгаажуулах ба 3 дахь сунгалтаас гэрчилгээнд хугацаагүй сунгаж болно	Зэрэг сунгах үйл явц	Зэргээ сунгуулах хүсэлтийг зэрэг авснаас хойшхи хугацаанд хийсэн ажил болон мэргэжил дээшлүүлсэн талаархи тайлан, тодорхойлолтын хамт зэргийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө зөвлөлд ирүүлнэ. Мэргэшсэн зэргийн хугацаагаа сунгуулахдаа: <ul style="list-style-type: none"> • Өөрийн биеэр ирж бүтээлээ шалгалтын комисст тайлагнана • Мэргэжлийн чиглэлээрээ 1-ээс доошгүй хууль, эрх зүйн баримт бичиг, норм, дүрэм, стандарт боловсруулахад заавал оролцсон,хянан тохиолдуулсан, санал өгч тусгуулсан, заавар, зөвлөмж, гарын авлага гаргасан байх
		Зам, барилгын үйлдвэрлэлд 6-аас доошгүй жил ажилласан байх. Авто замын тэргүүлэх инженерээс доошгүй зэрэгтэй, авто замын гэрээг боловсруулах туршлагатай ажлын тоо хэмжээ өртөг, түүний задаргааг ажлын технологитой нь уялдуулан бодитоор гаргаж, гэрээнд тусгагдсан ажлын тоо хэмжээ, хугацаа, өртөг зардалтай холбоотой нэхэмжлэх гаргах чадвар эзэмшсэн байх,	2. Салбарын мэргэжлийн сэтгүүл, хэвлэлд асуудал дэвшүүлсэн өгүүлэл, мэргэжлийн холбогдолтой 1-ээс доошгүй материал бичсэн байх.	3.Мэргэжлийн болон ур чадварын шалгалт нь /салбарын хууль, эрх зүйн баримт бичиг, норм норматив,стандарт, дүрэм, журам, заавар/ мэдлэгийг шалгах тест байх ба авбал зохих нийт онооны 85 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд тэнцсэнд тооцно.			Мэргэшсэн зэргийн хугацаа сунгуулахад биеэр ирж бүтээлээ шалгалтын комисст тайлагнах ба 85 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд сунгана.

Авто замын салбарын төсөвчин	Тэргүүлэх	Боловсрол	Төрөөс баримтлах боловсролын стандартыг хангасан их дээд сургууль төгсөж бакалаврын, боловсрол эзэмшихдээ Авто замын салбараар диплом хамгаалсан байх	1.Мэргэжилтний бүтээл туршлагыг магадлан үнэлэх /Загварын дагуу гаргасан бүтээлийн тайланг хянан магадлана./ 2.Мэргэжлийн болон ур чадварын шалгалт нь /салбарын хууль, эрх зүйн баримт бичиг, норм норматив,стандарт, дүрэм, журам, зааврын мэдлэгийг шалгах бичгээр хариулах асуулт болон тест байх ба авбал зохихнийт онооны 90 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд тэнцсэнд тооцно. 3. Сонгосон буюу оноож өгсөн сэдвээр реферат хамгаалан 80 ба түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн тохиолдолд тэнцсэнд тооцно. 4. Авто замын салбарын холбогдолтой эрдэм, шинжилгээ, судалгаа, инновацийн чиглэлээр 3-аас доошгүй материал салбарын хэвлэлд нийтлүүлсэн байх	Зөвлөх зэрэгтэй мэргэжилтэн нь 5 жил тутамд зэргээ сунгуулах ба 3 дахь сунгалтаас хугацаагүй болгоно	Зэрэг сунгуулах үйл явц	Зэргээ сунгуулах хүсэлтийг зэрэг авснаас хойшхи хугацаанд хийсэн ажил болон мэргэжил дээшлүүлсэн талаархи тайлан, тодорхойлолтын хамт зэргийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө зөвлөлд ирүүлнэ. Зөвлөх зэргийн хугацаагаа сунгуулахдаа: <ul style="list-style-type: none"> • Өөрийн биеэр ирж бүтээлээ шалгалтын комисст тайлагнана
		Ажилласан жил	Мэргэшсэн мэргэжилтний зэрэг авснаас хойш мэргэжлээрээ 9 ба түүнээс дээш жил тасралтгүй үр бүтээлтэй ажилласан байх,	Мэргэшсэн зэргээ тэргүүлэх зэрэгт ахиулахдаа: <ul style="list-style-type: none"> • Мэргэшсэн зэргээ зөвлөх зэрэгт ахиулах хүсэлт гаргасан бол зэрэг сунгах бүтээлээрээ тайлан хамгаалалтад орж тэнцсэн байна. • Мэргэжлийн ур чадварын мэдлэгийг шалгах тестийн шалгалтанд авбал зохих нийт онооны 90 буюутүүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн байх • Сэдвийн хамгаалалтад 80 буюу түүнээс дээш хувийн амжилт үзүүлсэн байна. 			
		Бусад шаардлага	Мэргэжлийн хүрээний чиглэлээр доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан тохиолдолд Тэргүүлэх зэрэг горилогчийн бичгээр уламжилсан хүсэлтийг үндэслэн зөвхөн мэргэжлийн шалгалтаас чөлөөлөх				